

# САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

---

“Монголросцветмет” ХХК-ийн 2018 оны санхүүгийн тайланд хийсэн аудит

**Аудитын код:** САГ-2019/7/СТА-ТБОӨААН

## Агуулга

1	Аудитын гэрчилгээ .....	2
2	Аудитын тайлан.....	4
	2.1. Оршил.....	4
	2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага .....	4
	2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт .....	4
	2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин .....	5
	2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ .....	5
	2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал .....	6
	2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар .....	7
	2.8. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн .....	7
	2.9. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал .....	7
	2.10. Үйл ажиллагааны орлого, зардал, гүйцэтгэл, түүний талаарх тайлбар, тодруулга.....	10
	2.11. Шилэн дансны мэдээлэл .....	10
	2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга .....	10
	2.13. Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	10
3	Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	13
	3.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	13
	3.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан.....	14
	3.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	15
	3.4 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан.....	16
	3.5 Аудит хийсэн зорилтот түвшин, гүйцэтгэл, түүний талаарх тайлбар, тодруулгын тайлан.....	17

## Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
НББОУС	Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
ТУЗ	Төлөөлөн удирдах зөвлөл
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани



## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг  
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр  
Утас:26-04-37, Факс:62-26-32-30  
E-mail: info@audit.gov.mn

МОНГОЛПРОСЦВЕТМЕТ ХХК-ИЙН  
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ҮҮРГИЙГ  
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ  
Б.МӨНХБАТ ТАНАА

2019.03.20 № 06/536  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Монголпросцветмет ХХК-ийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, тодруулгад санхүүгийн тайлангийн аудит хийв.

### Зөрчилгүй санал дүгнэлт

Монголпросцветмет ХХК-ийн оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт болон мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

### Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Монголпросцветмет ХХК-ийн 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, тодруулга дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.


071386

## Үүрэг, хариуцлага

Монголросцветмет ХХК нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН  
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

## **2 Аудитын тайлан**

### **2.1. Оршил**

“Монголросцветмет” ХХК-ийн 2018 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын дүн, дүгнэлтийг “Монголросцветмет” ХХК-ийн гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч Б. Мөнхбат Танд танилцуулж байна,

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

### **2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага**

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Монголросцветмет” ХХК-ийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайланд аудит хийлээ.

“Монголросцветмет” ХХК-ийн 2018 оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд санал дүгнэлт гаргах нь энэхүү аудитын зорилт байв.

“Монголросцветмет” ХХК-ийн удирдлага нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг НББОУС болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайланг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019.2.15-аас 2019.3.8-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019.3.13-ны өдөр эцэслэн баталгаажуулж, байгууллагын удирдлагад хүргүүлэхээр төлөвлөн, Ол дөш хайрхан аудит ХХК-ийн аудитор Ц. Бумцэнд, Ц. Саранцэцэг нар хариуцан хэрэгжүүлэв.

“Монголросцветмет” ХХК 2018 оны санхүүгийн тайлангаа 2019 оны 2 дугаар сарын 22-ны өдрийн 3/271 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

### **2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт**

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, НББОУС, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

## **2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин**

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

“Монголросцветмет” ХХК-ийн талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

### **Эрхэм зорилго:**

“Монголросцветмет” ХХКнь Монгол Улсын эдийн засгийн тулгуур салбарын хувьд ил тод, хариуцлагатай, аюулгүй, хүний эрүүл мэндэд халгүй, байгаль орчинд ээлтэй, харилцан ашигтай, хуулиа дээдэлсэн зарчмыг баримтлан уул уурхайн салбарын үйлдвэрлэлийг эрчимжүүлэх, өмнөө тавьсан зорилгод хүрэх зарчмыг баримталж, өрсөлдөх чадварынхаа давуу талыг дээд зэргээр ашиглахад үйл ажиллагаагаа чиглүүлэх зорилготой ажиллаж байна. гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Компанийн үйл ажиллагаандаа олон улсын стандартыг нэвтрүүлсэн, компанийн засаглалыг хөгжүүлсэн, Монгол Улсын хөгжилд оруулах хувь нэмрээ бататгасан, Монгол Улс төдийгүй олонулсад хүлээн зөвшөөрөгдсөн компани болох зорилт тавин ажиллаж байна.

“Монголросцветмет” ХХК нь 2018 онд хайлуур жоншны баяжмал 26.8 мянган тонн, болон алт 41 кг-г нийт 76,887.3 сая төгрөгийн өртгөөр олборлон, боловсруулж нийт 101,496.7 сая төгрөгийн борлуулалтын орлого олж, 14,265.7 сая төгрөгийн цэвэр ашигтай ажиллаж улсын төсөвт 13,511.3 сая төгрөг төвлөрүүлэхээр төлөвлөн ажилласан.

Тайлант хугацаанд хайлуур жоншны баяжмал 27.6 мянган тонн, төмрийн баяжмал 351.7 мянган тонн, төмрийн хүдэр /борлуулсан/ 882.7 мянган тонн болон 6.4 кг-г нийтдээ 66,127.3 сая төгрөгийн өртгөөр үйлдвэрлэж 82,215.4 сая төгрөгийн борлуулалтын орлого олж, улсын төсөвт 15,493.9 сая төгрөг төвлөрүүлж, 7,842.8 сая төгрөгийн цэвэр ашигтай ажилласан байна.

### **Үйл ажиллагааны чиглэл:**

“Монголросцветмет” ХХК-ийн дүрмийг 2018 оны 1 дүгээр сарын 9-ний өдрийн Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 06 дугаар тогтоолоор шинэчлэн баталж үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Хайлуур жонш, алт болон бусад ашигт малтмал олборлох, баяжуулах, борлуулах;
- Баяжмал болон бусад бэлэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх, борлуулах;
- Үйлдвэрлэсэн баяжмалыг металлургийн аргаар боловсруулах;
- МУ-ын нутаг дэвсгэр дээр геологи хайгуулын ажил, явуулах ашигт малтмалын орд газрыг үйлдвэрлэлийн аргаар эзэмшихэд бэлтгэх, ашиглах;
- Барилгын зураг төслийн ажил хийх, барилга байгууламж угсралт, монтаж, тохируулгын ажил гүйцэтгэх;
- Гадаадад бүтээгдэхүүнээ экспортлох, аж ахуйн үйл ажиллагаа явуулахад шаардлагатай материал, техник төхөөрөмж, импортлох;



- Монголын болон гадаадын үйлдвэр, аж ахуйн байгууллага болон нэгжтэй гэрээ, хэлэлцээр байгуулж, гэрээний нөхцөлийн дагуу тэдэнд зөвлөх болон бусад төрлийн үйлчилгээ үзүүлэх;

“Монголросцветмет” ХХК-ийн үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

“Монголросцветмет” ХХК-ийн удирдлага Сангийн сайдын баталсан нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Аудитын тухай хууль
- Компанийн тухай хууль
- Ашигт малтмалын тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Ашигт малтмалын тухай хууль
- Улсын Их Хурлын тогтоол, Засгийн газрын тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын тогтоол

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гарсан эсэх талаар дараах заалтад тэмдэглэв.

- Улсын Их Хурлын 2017 оны 23 дугаар тогтоол, Засгийн газрын 2018 оны 7 дугаар тогтоол, Засгийн газрын 2018 оны 1 дүгээр сарын 7-ний өдрийн хуралдааны тэмдэглэлээр өгсөн үүрэг даалгаврын дагуу Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2018 оны 6 дугаар тогтоолоор “Монголросцветмет” төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанийн дүрмийг баталж, улсын бүртгэлд бүртгүүлсэн байна. Гэхдээ өмчийн маргаан шүүхээр эцэслэн шийдвэрлэгдээгүй байна.
- Өмнөх онуудад ногдол ашиг ногдуулж байгаагүй бөгөөд Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар Төрийн өмчит болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийг үндэслэн 2018 оны 7 дугаар сарын 3-ны 322 тоот тогтоол гаргаж, 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан тэнцлийн цэвэр ашгийн дүнгээс бодож 1,571.3 сая төгрөгийн ногдол ашиг төсөвт төвлөрүүлэх болсон зэрэг асуудлууд тайлангийн хугацаанд шинээр гарсан байна.

## **2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ**

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Өмнөх оны аудитаар өгсөн зөвлөмжийн дагуу “Монголросцветмет” ХХК-ийн Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгээ Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцүүлэн боловсруулж, Ерөнхий захирлын 2018 оны 4 дүгээр сарын 9-ний өдрийн А/34 тоот тушаалаар батлуулсан байна..

“Монголросцветмет” ХХК-ийн санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагааг

үнэлэхэд мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

“Монголросцветмет” ХХК-ийн санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн “Даймонд” программ хангамж ашигладаг байна.

“Монголросцветмет” ХХК-ийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

## **2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал**

Аудитын явцад “Монголросцветмет” ХХК-ийн бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 7 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 7 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээ Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

## **2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар**

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгов.

Энэ нь тухайн компанид өмнөх 2 жилд бид аудит хийсэн бөгөөд гарсан алдаа зөрчлийг явцын дунд засуулах арга хэмжээ авсан тул эрсдэл бага гэж үзэж байна. Аудитаар нийт зардлын хэмжээнд тооцоход зохимжтой гэж үзсэн

“Монголросцветмет” ХХК-ийн 2018 оны суурь үзүүлэлт болох нийт зардал 74,372.6сая төгрөг бөгөөд түүний 1 хувь болох 743.7сая төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Материаллаг байдлыг суурь үзүүлэлтээс тооцох хувийг 1 хувиар тооцсон нь бүртгэл санхүүгийн ажилтнууд нь дадлага туршлага харьцангуй сайн явцын аудитаар зарим асуудлуудыг ойлголцож анхаарсан тул 1 хувиар материаллаг түвшинг тооцоход боломжтой гэж үзсэнтэй холбоотой болно.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

## **2.8. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн**

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 4 чиглэлээр аудитын 7 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 3 асуудлыг алдаа, зөрчилтөйд тооцож, 4асуудлыг алдаа, зөрчилд тооцохгүй гэж шийдвэрлэсэн.



Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээллийг В30103 маягтаар нэгтгэж, баримтжуулсан болно.

### 2.8.1 Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээлэл

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах асуудлуудаас залруулах алдаа илрээгүй болно.

Аудитын явцад илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

### 2.8.2 Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудал

Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг ангилсан байдал  
(Мянган төгрөгөөр)

№	Шийдэл	Тоо	Дүн	Тайлбар
1	Зөвлөмж өгсөн	3	480.7	
2	Төлбөрийн акт тогтоосон	0	0.00	
3	Албан шаардлага өгсөн	0	0.00	
4	Сахилгын шийтгэл ногдуулахаар шилжүүлсэн	0	0.00	
5	Хууль хяналтын байгууллагад асуудлыг шилжүүлсэн	0	0.00	
Дүн		3	480.7	

#### 2.8.2.1 Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлаас зөвлөмж өгөх асуудлыг Менежментийн захидалд оруулж, бусад хэлбэрээр шийдсэн алдаа, зөрчилтэй асуудлын дэлгэрэнгүйг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Үүнд:

#### Дотоод аудиттай холбоотой асуудал

"Монголросцветмет" ХХК-ийн Ерөнхий захирлын (өмнөх захирлын ) 2018 оны №А/195 тоот тушаалаар тооллогын комисс байгуулан тооллого хийхэд эргэлтийн хөрөнгөөс 1,4 сая төгрөгийн хөрөнгө 2018 онд Бор Өндөр Уулын баяжуулах үйлдвэрээс, "Монголросцветмет" ХХК-ийн орон сууц нийтийн аж ахуйд бүртгэлтэй зочид буудлын 10,0 сая төгрөгийн үнэ бүхий эргэлтийн хөрөнгө, 23.1 сая төгрөгийн анхны өртөгтэй, 4,4 сая төгрөгийн үлдэгдэл өртөг бүхий үндсэн хөрөнгө нь хувьчлалаар тараагдаж үгүй болсон зөрчил өмнөх онд гарч энэ асуудлыг шийдвэрлэхээр өгсөн зөвлөмж хэрэгжээгүй байна.

Энэ нь Оршин байх, Эрх ба үүрэг гэсэн батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1. Хөрөнгө, төлбөр тооцооны тооллого хийх зохион байгуулалтын асуудлыг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, ерөнхий нягтлан бодогч нар хариуцна; 20 дугаар зүйлийн 20.2.6.эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах; Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5. Захирлын гэм буруутай үйл ажиллагаа болон энэ хууль, гэрээнд заасан эд хөрөнгө эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхээ хэтрүүлэн буюу урвуулан ашиглах зэргээр тухайн үйлдвэрийн газарт хохирол учруулсан бол уг хохирлыг захирал өөрийн хувийн өмчийн эд хөрөнгөөр бүрэн хариуцна. " гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн: Дутагдсан хөрөнгийг төлүүлэх арга хэмжээг авах албан шаардлага хүргүүлэх;

## 2.9. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Дараах асуудлуудыг дараагийн аудитаар авч үзэх, анхаарал татсан асуудал гэж үзэж байна. Үүнд:

- Он удаан жил болсон, өр, авлагын асуудлыг шийдвэрлэх ажил бүрэн хийгдээгүй ;
- Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас тус компанийн өмчийн эзэмшлийн хувь, хэмжээ маргаантай байгаатай холбогдуулан хөрөнгийн дахин үнэлгээг 2019 онд хийх нь зүйтэй гэсэн аман шийдвэрийг өгснөөр хөрөнгийн дахин үнэлгээ хийгдээгүй байна. Энэ нь Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 193 дугаар тогтоолын заалтад нийцэхгүй байна. Харин тус компанийн ТУЗ 2019 оны 1 дүгээр сарын 7-ны өдрийн 01 тоот тогтоолоороо Компанийн 2019 оны бизнес төлөвлөгөө болон худалдан авалтын төлөвлөгөөнд нь 110.0 сая төгрөгийн төсөв баталсан ;
- Улсын Их Хурлын 2017 оны 23 дугаар тогтоол, Засгийн газрын 2018 оны 07 дугаар тогтоол, Засгийн газрын 2018 оны 1 дүгээр сарын 4-ний өдрийн хуралдааны тэмдэглэлээр өгсөн үүрэг даалгаврын дагуу Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2018 оны 6 дугаар тогтоолоор “Монголросцветмет” төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанийн дүрмийг баталж, Оюуны өмч, улсын бүртгэл ерөнхий газар Хуулийн этгээдийн бүртгэлийн газраас 2018 оны 1 дүгээр сарын 19-ний өдөр олгосон хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээгээр 1 гишүүнтэй, 1,226.8 сая төгрөгийн өөрийн хөрөнгөтэй гэсэн байна.

Гэтэл Монгол Улсын Дээд шүүхийн 2018 оны 9 дүгээр сарын 19-ний өдрийн хурлаар хэлэлцэж, “Монголросцветмет” ХХК-ийн 49 хувийн хувьцааны өмчлөлийг төрд шилжүүлсэн Засгийн газрын 2017 оны 14 дүгээр тэмдэглэл, 2018 оны 7 дугаар тогтоол, түүнийг дагаж Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас баталсан үйлдвэрийн дүрэм болон хувьцаа эзэмшигчийн өөрчлөлт бүртгэсэн улсын бүртгэлийг хүчингүй болгосон байна.

Мөн Хууль зүй дотоод хэргийн яамны 2018 оны 12 дүгээр сарын 06-ны өдрийн 1-3/5919 , Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2018 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн А-1/4186 тоот албан бичгүүдээр тус компанийн 49 хувийн хувьцаатай холбоотой шүүхийн маргаан эцэслэн шийдвэрлэгдээгүй, Улсын Их Хурлаас 2009 оны 1 дүгээр сарын 15-ны өдрийн Хэлэлцээр соёрхон батлах тухай хуулиар соёрхон баталсан “Монголросцветмет” ХХК-ийн үйл ажиллагааны тухай Монгол Улсын Засгийн газар, Оросын Холбооны Улсын Засгийн газар хоорондын 2007 оны 4 дүгээр сарын 25-ны өдрийн хэлэлцээрийг соёрхон баталсан Хэлэлцээр соёрхон батлах тухай 2009 оны 1 дүгээр сарын 16-ны хууль одоогоор хүчинтэй үйлчилж байгаа гэсэн албан тоот ирүүлсэн байна.

Ийнхүү дээд байгууллагуудаас зөрүүтэй баримт бичгүүд гаргасан нь аудит хийхэд хүндрэлтэй байна. Иймээс тус компанийн өмчтэй холбоотой асуудлыг онцгойлон авч үзэх асуудал гэж үзэж байна.

- Бүтээгдэхүүн борлуулалттай холбоотой гэрээ түүний биелэлтийг авч үзэхэд жоншны борлуулалтын үнэ Засгийн газраас тогтоосон үнээс бага, харин төмрийн хүдэр, хүдрийн баяжмалын борлуулалтын үнэ Монгол Улсын Засгийн Газрын 2015 оны 103 дугаар тогтоолоор баталсан үнээр тооцогдож байна.

**2.10. Үйл ажиллагааны орлого, зардал, гүйцэтгэл, түүний талаарх тайлбар, тодруулга**

2018 оны бизнес төлөвлөгөөг 2018 оны ,2 дугаар сард Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын гарын 37 дугаар тогтоолоор баталж,, хэрэгжилтийг ханган биелүүлэх ажлыг хийж гүйцэтгэсэн байна.

Төлөвлөгөөний биелэлтийг авч үзвэл: 82,215.4 сая төгрөгийн борлуулалтын орлого олж төлөвлөсөн хэмжээнээс 24,720.0 сая төгрөгөөр төлөвлөгөөгөө тасалсан Энэ нь төмрийн хүдрийн олборлолтын хэмжээ 2,400 мянган тонн байхаар төлөвлөснөөс 1,669 мянган тонныг олборлосонтой холбоотой байна.

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
Борлуулалтын орлого	101,495.7	82,215.4
Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	77,650.3	65,758.4
Борлуулалт ,маркетингийн зардал	12.039.3	11,866.4
Ерөнхий ба удирдлагын зардал	5,482.5	4.179,0
Тайлант үеийн ашиг, алдагдал		7,842.8

**2.11. Шилэн дансны мэдээлэл**

“Монголросцветмет” ХХК-ийн Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

“Монголросцветмет” ХХК-нь шилэн дансаар 3 төрлийн мэдээлэл тавихаас 1 төрлийн тухайлбал тендерийн материалыг байршуулснаас өөр мэдээлэл байршуулаагүй байна.

Тус байгууллагын Шилэн дансны тухай хуулиар хүлээсэн үүргийн биелэлт бүрэн биелүүлээгүй байна..

**2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга**

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн биелэлт 2018 оны жилийн эцсийн байдлаар 87хувьтай байна.

Өмнөх оны аудитаар илэрч байсан хөрөнгө дутагдсан болон “Бор Өндөр” Уулын баяжуулах үйлдвэрийн дансанд бүртгэлтэй орон сууц, нийгэм соёлын зориулалттай байгууламжийг орон нутагт нь хүлээлгэн өгөх асуудлыг ТУЗ-ийн хуралд оруулж шийдвэрлүүлэх зөвлөмж өгсөн нь бүрэн хэрэгжээгүйтэй холбоотой байна.

Эдгээр зөвлөмжийн биелэлтийн талаарх мэдээллийг ажлын баримт материалд хадгалсан бөгөөд гүйцэтгэлийг аудитын явцад дахин нягталсан болно.

**2.13. Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл**

Бид“Монголросцветмет” ХХК-ийн 2018 оны санхүүгийн тайланд аудит хийхдээ АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Монголросцветмет” ХХК-ийн 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн тайлан болон бусад илчлэл тодруулгад тусгасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдийг холбогдох хууль, стандартад нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

### **3. Менежментийн захидал**

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидал АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтэд үндэслэсэн болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь “Монголросцветмет” ХХК-ийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

#### **3.1. Балансын данстай холбоотой асуудал**

##### **3.1.1 Илрүүлэлт:**

“Монголросцветмет” ХХК-ийн 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангаарх үлдэгдлээс 1.8 хувь буюу 63.6 сая төгрөгийн авлагыг баталгаажуулаагүй байна. Нийт авлагын насжилтыг авч үзвэл: 2017 он болон түүнээс өмнө үүссэн авлага нийт авлагын 13.3 хувийг эзэлж байна. Эдгээр авлагаас 383.7 сая төгрөгийн авлага нь 2014 он болон түүнээс өмнө үүссэн, барагдуулах найдваргүй авлага байна.

Оны эцэст дансны 9.690,2 сая төгрөгийн өртэй гарснаас 9,366.5 сая төгрөг буюу 96.6 хувийг актаар баталгаажуулж 211,8 сая төгрөгийн өрийг баталгаажуулаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ”, 20.2.6. “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” гэсэн заалттай нийцэхгүй байна.

##### **3.1.2 Эрсдэл**

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн холбогдох заалт зөрчигдөх, найдваргүй авлага нэмэгдэх эрсдэлтэй;

##### **3.1.3 Өгсөн зөвлөмж**

**Авлагын үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулах, авлагыг барагдуулах;**

##### **3.1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:**

63.6 сая төгрөгийн авлагыг 2019 оны эхний улиралд барагдуулахаар ажиллаж байна. 211.8 сая төгрөгийн өр төлбөрийг хуулийн хөөн хэлэлцэх хугацааны дагуу шийдвэрлэх болно.

### **3.2 Балансын данстай холбоотой асуудал**

#### **3.2.1 Илрүүлэлт:**

Үндсэн хөрөнгөөс цаашид ашиглах боломжгүй, эвдэрч хэмхэрсэн, элэгдэлд орж хуучирсан, технологийн хувьд хоцрогдсон, анхны өртгөө элэгдлээрээ бүрэн нөхсөн бөгөөд зориулалтаар нь ашиглах боломжгүй болсон зэрэг үндэслэлээр нийт 5,477.7 сая төгрөгийн анхны өртөгтэй, 180,7 сая төгрөгийн үлдэгдэл өртөгтэй 844 тоо ширхэг бүхий үндсэн хөрөнгө, 49 нэр төрлийн 8,8 сая төгрөгийн үнийн дүнтэй материал байна.

#### **3.2.2 Эрсдэл:**

Энэ нь хөрөнгийн үр ашиг буурах, ашиг, алдагдалд нөлөөлөх эрсдэлтэй.

#### **3.2.3 Өгсөн зөвлөмж:**

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт энэ асуудлыг тавьж шийдвэр гаргуулах;

#### **3.2.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:**

Тооллогын үр дүнг Компанийн өмч хамгаалах байнгын комисс-д танилцуулсанбөгөөд асуудлыг шийдвэрлүүлэхээр ТУЗ-ийн хурлыг хүлээж байна.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг үндэсний аудитын газарт 2019 оны 7 дугаар сарын1-ний дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**4. Аудит хийсэн санхүүгийн тайлан**

**4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан /төгрөгөөр/

Мөрийн дугаар	БАЛАНСЫН ЗҮЙЛ	2017 оны 12-р сарын 31	2018 оны 12-р сарын 31
<b>1</b>	<b>ХӨРӨНГӨ</b>		
<b>1.1</b>	<b>Эргэлтийн хөрөнгө</b>		
1.1.1	Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	2,140,628,114.41	4,355,003,139.19
1.1.2	Дансны авлага	3,055,437,852.01	1,834,675,213.57
1.1.3	Татвар, НДШ-ийн авлага	930,650,090.27	1,667,198,353.74
1.1.6	Бараа материал	19,293,716,599.06	22,143,901,759.60
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	4,452,450,586.73	3,479,760,972.81
<b>1.1.11</b>	<b>Эргэлтийн хөрөнгийн дүн</b>	<b><u>29,872,883,242.48</u></b>	<b><u>33,480,539,438.91</u></b>
<b>1.2</b>	<b>Эргэлтийн бус хөрөнгө</b>		
1.2.1	Үндсэн хөрөнгө	26,357,986,042.54	28,381,306,725.04
1.2.2	Биет бус хөрөнгө	1,979,869,627.22	2,139,283,610.82
1.2.4	Урт хугацаат хөрөнгө оруулалт	2,158,820,000.00	2,158,820,000.00
1.2.5	Хайгуул ба үнэлгээний хөрөнгө	2,746,411,872.98	3,097,281,327.12
1.2.9	Дуусаагүй барилга	1,445,635,002.83	1,445,635,002.83
1.2.10	<b>Эргэлтийн бус хөрөнгийн дүн</b>	<b><u>34,688,722,545.57</u></b>	<b><u>37,222,326,665.81</u></b>
<b>1.3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>64,561,605,788.05</u></b>	<b><u>70,702,866,104.72</u></b>
<b>2</b>	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗЭМШИГЧИЙН ӨМЧ</b>		
<b>2.1</b>	<b>ӨР ТӨЛБӨР</b>		
<b>2.1.1</b>	<b>Богино хугацаат өр төлбөр</b>		
2.1.1.1	Дансны өглөг	6,075,065,085.49	9,690,203,133.91
2.1.1.2	Цалингийн өглөг	1,029,378,868.05	953,294,322.00
2.1.1.3	Татварын өр	6,909,459,935.04	5,195,447,981.23
2.1.1.4	НДШ-ийн өглөг	4,895,732,693.15	1,459,789,883.83
2.1.1.5	Богино хугацаат зээл	8,599,570,079.57	25,880,597,991.14
2.1.1.6	Хүүгийн өглөг	5,639,714,170.14	44,063,408.25
2.1.1.7	Ногдол ашгийн өглөг	-	1,371,317,600.00
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	11,071,483,264.50	10,718,806,758.09
2.1.1.9	Нөөц / өр төлбөр /	1,674,583,594.59	2,019,186,993.36
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	9,243,487,380.47	7,209,446.10
2.1.1.13	<b>Богино хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b><u>55,138,475,071.00</u></b>	<b><u>57,339,917,517.91</u></b>
<b>2.1.2</b>	<b>Урт хугацаат өр төлбөр</b>		
2.1.2.3	Хойшлогдсон татварын өр	205,921,754.71	155,340,343.09
2.1.2.4	Бусад урт хугацаат өр төлбөр	13,361,350,650.00	11,080,236,150.00
2.1.2.6	<b>Урт хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b><u>13,567,272,404.71</u></b>	<b><u>11,235,576,493.09</u></b>
<b>2.2</b>	<b>Өр төлбөрийн нийт дүн</b>	<b><u>68,705,747,475.71</u></b>	<b><u>68,575,494,011.00</u></b>
<b>2.3</b>	<b>2. Эзэмшигчдийн өмч</b>		
2.3.1	Өмч : а) төрийн	625,661,880.00	1,226,788,000.00
2.3.2	б) хувийн	601,126,120.00	
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	12,265,209,146.83	12,265,209,146.83
2.3.9	Хуримтлагдсан ашиг	-17,636,138,834.49	-11,364,625,053.11
2.3.9.1	Тайлангийн үеийн	15,713,176,281.08	7,842,831,381.38
2.3.9.2	Өмнөх үеийн	-33,349,315,115.57	-19,207,456,434.49
<b>2.3.11</b>	<b>Эзэмшигчдийн өмчийн дүн</b>	<b><u>-4,144,141,687.66</u></b>	<b><u>2,127,372,093.72</u></b>
<b>2.4</b>	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗЭМШИГЧИЙН ӨМЧИЙН ДҮН</b>	<b><u>64,561,605,788.05</u></b>	<b><u>70,702,866,104.72</u></b>



**4.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан**

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан /төгрөгөөр/

Д/д	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	<b>Борлуулалтын орлого ( цэвэр )</b>	<b>82,883,896,000.82</b>	<b>82,215,408,292.06</b>
2	Борлуулалтын өртөг	41,927,712,796.07	50,081,891,323.91
3	<b>Нийт ашиг ( алдагдал )</b>	<b>40,956,183,204.75</b>	<b>32,133,516,968.15</b>
4	Түрээсийн орлого	224,508,552.69	913,275,809.37
5	Хүүгийн орлого	35,122,390.43	46,061,597.58
8	Бусад орлого	4,159,481,679.23	4,097,778,866.22
9	Борлуулалт, маркетингийн зардал	10,583,373,665.21	11,866,423,553.90
10	Ерөнхий ба удирдлагын зардал	3,271,276,417.22	4,179,008,517.79
11	Санхүүгийн зардал	2,355,052,324.80	1,791,281,383.81
12	Бусад зардал	8,648,265,980.98	7,420,560,303.69
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз )	850,762,050.64	-218,176,956.09
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз )	-3,162,379.19	-247,688.85
18	<b>Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал )</b>	<b>21,364,927,110.34</b>	<b>11,714,934,837.19</b>
19	Орлогын татварын зардал	5,651,650,829.26	3,872,103,455.81
20	<b>Татварын дараах ашиг ( алдагдал )</b>	<b>15,713,276,281.08</b>	<b>7,842,831,381.38</b>
22	<b>Тайлант үеийн цэвэр ашиг ( алдагдал )</b>	<b>15,713,276,281.08</b>	<b>7,842,831,381.38</b>

### 4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан /төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
2016 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	1,226,788,000.00	12,265,209,146.82	- 33,349,315,115.57	- 19,857,317,968.74
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)			15,713,176,281.08	15,713,176,281.08
2017 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	1,226,788,000.00	12,265,209,146.82	- 17,636,138,834.49	- 4,144,141,687.66
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)			7,842,831,381.38	7,842,831,381.38
Ногдол ашиг			- 1,571,317,600.00	- 1,571,317,600.00
2018 оны 12-р сарын 31-ны үлдэгдэл	1,226,788,000.00	12,265,209,146.82	- 11,364,625,053.11	2,127,372,093.72

#### 4.4 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан /төгрөгөөр/

д/д	ҮЗҮҮЛЭЛТ	Өмнөх он	Тайлант он
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	<b>Мөнгөн орлогын дүн</b>	<b>90,318,992,984.80</b>	<b>94,387,552,206.60</b>
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	87,731,487,200.29	91,050,618,678.53
1.1.3	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	11,237,252.30	6,779,089.00
1.1.6	Бусад мөнгөн орлого	2,576,268,532.21	3,330,154,439.07
1.2	<b>Мөнгөн зарлагын дүн</b>	<b>75,282,333,336.21</b>	<b>92,826,664,661.32</b>
1.2.1	Ажиллагчдад төлсөн	16,863,711,365.27	19,076,489,533.76
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	4,284,616,867.94	8,121,488,147.43
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	12,708,085,089.54	15,262,545,549.11
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	13,629,960,468.69	13,579,033,539.12
1.2.5	Түлш, шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	16,404,342,291.43	15,021,848,028.19
1.2.6	Хүүгийн төлбөрт төлсөн	1,172,486,532.41	1,752,075,585.79
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	9,897,343,367.54	12,181,754,231.64
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн	46,785,904.00	53,721,671.00
1.2.9	Бусад мөнгөн зарлага	275,001,449.39	7,777,708,375.27
1.3	<b>Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>15,036,659,648.59</b>	<b>1,560,887,545.28</b>
2.1	<b>Мөнгөн орлогын дүн</b>	<b>30,895,130.13</b>	<b>46,062,013.37</b>
2.1.6	Хүлээн авсан хүүгийн орлого	30,895,130.13	46,062,013.37
2.2	<b>Мөнгөн зарлагын дүн</b>	<b>1,047,439,494.77</b>	<b>1,778,985,487.24</b>
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	1,047,439,494.77	1,778,985,487.24
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	1,016,544,364.64	1,732,923,473.87
3.1	<b>Мөнгөн орлогын дүн</b>	-	<b>22,191,800,000.00</b>
3.1.1	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан		22,191,800,000.00
3.2	<b>Мөнгөн зарлагын дүн</b>	<b>12,626,707,352.76</b>	<b>19,896,071,251.31</b>
3.2.1	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн	12,626,707,352.76	19,696,071,251.31
3.2.4	Төлсөн ногдол ашиг		200,000,000.00
3.3	<b>Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>12,626,707,352.76</b>	<b>2,295,728,748.69</b>
4	Валютын ханшийн зөрүү	180,645,098.16	90,682,204.68
5	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	<b>1,212,762,833.03</b>	<b>2,214,375,024.78</b>
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	<b>927,865,281.38</b>	<b>2,140,628,114.41</b>
7	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	<b>2,140,628,114.41</b>	<b>4,355,003,139.19</b>

**5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт**

Огноо:	2019.03.09	Аудитын нэр:	Монголросцветмет ХХК-ийн 2018 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан	Аудитын код:
Шалгагдсан байгууллагын нэр:	Монголросцветмет ХХК			САГ-2019/7/СТА-ТШЗ
				Сая төгрөгөөр

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
А	1	2	3	4	5
1	Өмнөх онд 11,357,1 мянган төгрөгийн эргэлтийн хөрөнгө, 4.442.9 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө дутагдсан зөрчил илэрч энэ зөрчлийг барагдуулах зөвлөмж өгөгдсөн боловч шийдвэрлэгдээгүй	15.8	Дутагдсан хөрөнгийг төлүүлж хохирлыг арилгах албан шаардлага өгөх	Гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч, ерөнхий нягтлан бодогч,	Б. Мөнхбат, Д. Баярбат
2	Өглөг, авлагын барагдуулалт хангалтгүй, 63.6 сая төгрөгийн авлага, 211.8 сая төгрөгийн өглөгийн үлдэгдэл актаар баталгаажаагүй .	275.4	Зөрчлийг давтан гаргахгүй байх, холбогдох хуулийн заалтыг хэрэгжүүлэх зөвлөмж өгөх	Гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч, ерөнхий нягтлан бодогч	Б. Мөнхбат, Д. Баярбат
3	Үндсэн хөрөнгөөс цаашид ашиглах боломжгүй, эвдэрч хэмхэрсэн, элэгдэлд орж хуучирсан, технологийн хувьд хоцрогдсон, анхны өртгөө элэгдлээрээ бүрэн нөхсөн бөгөөд зориулалтаар нь ашиглах боломжгүй болсон зэрэг үндэслэлээр нийт 5,477.7 сая төгрөгийн анхны өртөгтэй, 180,7 сая төгрөгийн үлдэгдэл өртөгтэй 844 тоо ширхэг бүхий үндсэн хөрөнгө байна. Бор Өндөр"-ийн УБҮ-ийн үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд ашиглагдахгүй байгаа цаашид ашиглах боломжгүй (техник тоног төхөөрөмж нь ашиглагдахгүй болсон, хуучин, элэгдэлд орсон г.м) 49 нэр төрлийн 8,8 сая төгрөгийн үнийн дүнтэй материал байна. Энэ нь СТОУС 13-н дагуу аливаа хөрөнгийг бодит үнэ цэнээр илэрхийлэгдэх гэсэн шаардлагыг хангахгүй байна.	189.5	СТОУС 13-н дагуу аливаа хөрөнгийг бодит үнэ цэнээр илэрхийлэгдэх гэсэн шаардлагыг хангаж ажиллах, ТӨБЗ Г-т асуудлыг тавьж шийдвэр гаргуулах гэсэн зөвлөмж өгөх.	Гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч, ерөнхий нягтлан бодогч,	Б. Мөнхбат, Д. Баярбат
	<b>Дүн</b>	<b>480.7</b>			



